



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 17/189

Мандалговь

“Таван богд” ХХК-тай
гэрээ байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засварын хөдлөх хөрөнгийн их засвар үйлчилгээний батлагдсан зардлаас “0001ДУА дугаартай авто машины засвар” ажлыг “Таван богд” ХХК-тай 4,289,100 (дөрвөн сая хоёр зуун наян есөн мянга нэг зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Гэрээнд заасан хугацаанд “0001ДУА дугаартай авто машины засвар” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Таван богд” ХХК-ний гүйцэтгэх захирал (Ж.Барсболд)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Үйлчилгээний албаны дарга (М.Батсайхан) гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150463